



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 01 едөр

Дугаар #/33

Алтанбулаг

Г Согтууруулах ундаа худалдах,
түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг
шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6 “ж”, 39 дүгээр зүйлийн 39.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1, Коронавируст халдварт /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нелөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийн 11.1.1, 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.3, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн “Түр журам батлах тухай” 18 дугаар тушаал, Монгол Улсын стандарт “MNS ISO/PAS 45005:2021”, Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/59 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн согтууруулах ундаа худалдах цагийн хязгаарыг 10:00-22:00 цаг хүртэл байхаар тогтоосугай.

2. Сонгуулийн санал авах өдөр, цэрэг татлага, жагсаал цуглаан зохион байгуулагдаж байгаа өдрүүд болон сар бүрийн 01-ний өдрийн 00:00 цагаас 02-ны өдрийн өглөөний 10 цаг хүртэлх хугацаанд сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдахыг тус тус хориглосугай.

3. Худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаанд тавигдах тусгай шаардлага, нөхцөлийг ханган, ариутгал, халдвартгуйжүүлэлтийн ажлыг тогтмол хийж, халдварт хамгааллын дэглэмийг сахин, коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлж ажиллахад хяналт тавьж ажиллахыг ХАА-н тасгийн мэргэжилтэн /Б.Одмаа/-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /У.Янжиндулам/, Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн дэд хурандаа /Д.Наран/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ОГОНЦОГТ